

**ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ**  
**(2024 оны III улирлын түүвэр судалгааны тайлан)**

**Судалгааны товч үр дүн**

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2024 оны 8-р сарын 20-оос 9-р сарын 3-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 21 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

**Шинжээчид:**

**2024 оны III улиралд**

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 6.1%,
- Эдийн засгийн өсөлт 5.9%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 11.0%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.2% болно гэж таамагласан байна.

**2025 оны II улиралд**

- Инфляц нэмэгдэж 7.0%,
- Эдийн засгийн өсөлт 6.0%,
- Бодлогын хүү 10.7%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.1% болно гэж таамагласан байна.

**Судалгааны нэгдсэн үр дүн**

Огноо	2024 он 7 сар	2024 он III улирал	2025 оны II улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	5.0%	<b>6.1%</b>	<b>7.0%</b>
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	5.6%*	<b>5.9%</b>	<b>6.0%</b>
Төв банкны бодлогын хүү /%/	11.0%	<b>11.0%</b>	<b>10.7%</b>
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	16.8%	<b>16.2%</b>	<b>16.1%</b>

\* 2024 оны хагас жил


*Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.*

© **МОНГОЛБАНК**, 2024

## I. Инфляц


2024 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын жилийн инфляц 5.0% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 1.8 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2024 оны III улиралд инфляц 6.1%, жилийн дараа 7.0% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

**Зураг 1. Инфляцын таамаглал**




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны III улиралд инфляц 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 34.7%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны III улиралд инфляц 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.3% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

**Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2024 оны III улирал/**




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурсан хэдий ч цаашид бага зэрэг өсөх хандлагатай байна. Шинжээчид 2024 оны III улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 7.2% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.1% гэж таамаглажээ (Зураг 3).

**Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт**



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.0-6.3% орчимд байна (Зураг 4).


**Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2024 оны III улирал/**



## II. Эдийн засгийн өсөлт


2024 оны эхний хагас жилийн байдлаар бодит ДНБ-ий жилийн өсөлт 5.6% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 1.4 нэгж хувиар бага гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2024 оны III улиралд 5.9%, 2025 оны II улиралд 6.0% гэж таамаглаж байна (Зураг 5).

**Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал**




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2024 оны III улиралд 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.6% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2024 оны III улиралд өсөлт 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 27.2% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

**Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2024 оны III улирал/**




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурах хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2024 оны III улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 6.8%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 5.9% байна гэж таамаглажээ (Зураг 7).

**Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт**



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 5.8-6.0% орчимд байна (Зураг 8).


**Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2024 оны III улирал/**



### Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2024 оны III улиралд дунджаар 11.0%, хамгийн ихдээ 13.0%, хамгийн багадаа 10.0% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2025 оны II улиралд 10.7% байна гэж таамаглажээ (Зураг 9).

**Зураг 9. Бодлогын хүүний таамаглал**



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2024 оны III улиралд бодлогын хүү 11.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 10).


**Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2024 оны III улирал, хариултын тоогоор/**



2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг аажмаар нэмэгдүүлсээр мөн оны эцэст 13% хүргэсэн бол 2024 оны 3 сараас бодлогын хүүг бууруулж өнөөгийн байдлаар 11%-д хүргээд байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 2 улирал дараалан шинжээчдийн таамаглал буурах

хандлага ажиглагдлаа. Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны III улирлын бодлогын хүүг 11.1% байна таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар өнөөгийн түвшинд 11.0% хэвээр байна гэж таамаглажээ (Зураг 11).


**Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**



### IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2024 оны III улиралд дунджаар 16.2%, хамгийн ихдээ 17.0%, хамгийн багадаа 15.5%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг буурч 2025 оны II улиралд 16.1% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

**Зураг 12. Зээлийн хүүний таамаглал**



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2024 оны III улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 15.6-16.0% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

**Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2024 оны III улирал, хариултын тоогоор/**



Зээлийн хүүний таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын үр дүнтэй харьцуулан авч үзвэл бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. 2024 оны II улиралд шинээр олгосон зээлийн

жигнэсэн дундаж хүү бага зэрэг буурсантай холбоотойгоор шинжээчдийн таамаглал мөн буурчээ. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2024 оны III улиралд зээлийн хүүг 16.7% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.2% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

**Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт**

